

Ойр болон холын хэтийн төлөвийн тухайд ахул, нийгэм судлаачид улс орныхоо хурдан түргэн бөгөөд зохистой хөгжлийг хангах тийм онолын харилцааг онолын баттай чиг баримжааг боловсруулах үүрэгтэй.

Нам улсын зохион байгуулах ажлыг өөрчлөн байгуулалт ба шинэ ач холбогдолт сэтгэлгээний дагуу шинэ шатнаа гартал эрс сайжруулан өрнүүлэх хэрэгт түүхч, философич, эдийн засагчдын зоригтой онолын сэтгэлгээ шаардагдаж байна. Монгол орон маань XXI зуунд ямар болох тухай сүүл 1970-аад загварыг шинэ сэтгэлгээгээр хамтын хүчээр боловсруулах хэрэгтэй болжээ.

Дээр дурдсан зүйлд нэмж өгүүлэхэд манайд түүхийн зохиол болон сурах бичгүүдэд Чойбалсангийн ролийг түүний буруу зөв үгийн хамт шагшин магтаж, ганц Сталинг шинжлэх ухааны үнэнийг салбар салбараар тодорхойлоход эцсийн үгээ хэлж суудаг ямар нэг ид шид мэт дэвэргэж билээ. Чойбалсан, Сталиныг тахин шүтэх явдал шинжлэх ухааны талбарт ч хүчээр нэвтэрч, тус орны байгаль, нийгмийн шинжлэх ухаанд албадах, захиргаадах, айлган сүрдүүлэх арга, хоосон бясалгал, догматизм дэлгэрч, хөгжилд нь чөдөр тээг болж байжээ.

Нөгөө талаар, түүхийн үйл явдлууд эзэнгүйдэж, хамгийг хөдөлгөгч хүчин нь Сталин, Чойбалсан нар болж хувирчээ.

Түүхийн үнэнийг сэргээх бас нэг чухал асуудал бол хилсээр хэлмэгдэн амь үрэгдсэн манай нам төрийн нэрт зүтгэлтнүүд, түүний дотор ерөнхий сайд Амар, Гэндэн, бүх цэргийн жанжин Дэмид, мөн түүнчлэн энгийн номхон ард иргэдийг нэгийг ч орхилгүй цагаатган, нэр хүндийг нь хэдүй амь буснисан хойно нь ч гэсэн сэргээх нь бүх шударга хүмүүсийн ариун үүрэг мөн. Энэ бол манай нам, засгийн анхаарлын төвд байх ёстой асуудал байна.

Одоо бид сэтгэлд сэв суусан тэр гамшигт үеийн гай уршгаас бүрэн тусгаарлан зааглаж, ард түмнийхээ нэр төр, буурь суурийг гадаад дотоодод хүндэтгэн, эх орныхоо сайн сайхны төлөө гэсэн хэзээ ч шантраагүй эрмэлзлэлийг нь эрхэмлэн дээдэлж байх үүрэгтэй.

ЗӨВЛӨЛТ, ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ОЛОН МЯНГАН ТҮҮХЭН ШИНЭ ҮЕ

Аргын 1989 он, Билгийн тооллын XVII жарны шаргачин могой жил манай хоёр их хөрш ЗСБНХУ, БНХАУ-ын харилцаанд онцгой жил юм. Энэ онд БНХАУ-ыг тунхагласны 40 жилийн ой, ЗСБНХУ, БНХАУ дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг тэмдэглэх болно. Чухам энэ үед ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга М. С. Горбачев БНХАУ-д албан ёсны айлчлал хийж, хятад улсын нам, төрийн удирдагчидтай уулзаж, хэлэлцээ хийсэн нь удахгүй тэмдэглэх ойнуудыг улам утга төгөлдөр болгох төдийгүй, хоёр улсын харилцааны түүхэн шинэ үеийг нээлээ.

М. С. Горбачевын БНХАУ-д хийсэн айлчлал нь зөвхөн хоёр улсын харилцааг хэвийн болгосон төдийгүй 1989 оны олон улсын амьдралын онцгой чухал үйл явдалд зүй ёсоор тооцогдох дэлхий дахины ач холбогдолтой айлчлал болов.

ЗСБНХУ, БНХАУ дипломат харилцаа тогтоосноос хойш энэ хоёр их гүрний харилцаа тэр бүр сайн сайхан байсангүйн улмаас 1960 оны сүүл 1970-аад онд харилцаа нь зогсонги байдалд орж байлаа.

Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, эдийн засаг, цэргийн хүчин чадал, дэлхий дахинд үзүүлэх нөлөөгөөрөө асар их ЗСБНХУ, БНХАУ харилцаагаа хэвийн болгож сайжруулах нь хоёр орны харилцаанд төдийгүй Ази, Номхон далайн бүс нутаг, дэлхийн энх тайван, аюулгүй байдлын үйл хэрэгт чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн гучин жилд анх удаа болсон энэхүү дээд хэмжээний уулзалт нь хоёр улсын хамтын хүчин чармайлтын үрээр харилцааны бүхий л салбарт ахиц дэвшилд хүрсэн таатай сайхан нөхцөл боллоо.

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга М. С. Горбачевтай ХКН-ын Төв Хорооны цэргийн зөвлөл, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн дарга Дэн Сяопин уулзаж ярилцахдаа «Урьдын явдлыг салхи үлээн хийсгэг, урагшаа харцгаая» гэж онцлон тэмдэглэсэн билээ. Энэ бол өнгөрсөн үеийн сургамжийг хоёр улс аль аль нь сайтар ойлгож, зохих дүн шинжилгээ хийсний шууд үр дүн болох нь эргэлзээгүй.

Энэхүү дээд хэмжээний уулзалтаар ЗХУКН, ХКН-ын хоорондын харилцаа сэргэснийг энд онцлон тэмдэглэж байна. Хоёр улсын гадаад, дотоод бодлогыг боловсруулдаг эрх баригч намууд хараат биш, бие даасан, бүрэн тэгш байж, харилцан хүндэтгэх, бие биеийнхээ дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмын дагуу хэлхээ холбоотой байхаар» тохиролцсон нь хоёр улсын цаашдын харилцааг хөгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой юм.

ЗХУ, БНХАУ-ын улс төрийн гадаад бодлогын зорилтууд олон талаар ижил төсөөтэй байгаа нь харагдаж байна. Хоёр улс зэвсэглэлийг хураах, намжмал байдлыг гүнзгийрүүлэх, хөршийн сайн харилцааг хөгжүүлэх, гурав дахь орны эрх ашгийг үл хөндөх, Ази, Номхон далайн бүс нутаг, дэлхий дахинд тогтвортой байдал, хамтын ажиллагааг өрнүүлэх, маргаантай асуудлуудыг эв зүйгээр шийдвэрлэх эрмэлзлэлтэй байна.

Олон мянган километр үргэлжилсэн ЗХУ, БНХАУ-ын хилийг энх тайван, найрамдлын хил болгохыг хоёр тал эрмэлзэж байна. БНХАУ армия 1 сая хүнээр цөөрүүлсэн бол ЗХУ нутгийнхаа Азийн хэсэг дэх ойр, дунд тусгалын пуужингаа устгаж, зэвсэгт хүчнээ 1989-1990 онд зохих хувиар цөөрүүлэх юм. Үүнээс гадна 1987 онд манай орноос зөвлөлтийн цэргийн нэг дивиз, хэд хэдэн ангийг гаргасан бөгөөд зөвлөлтийн засгийн газар, манай улсын засгийн газартай тохиролцсоны дагуу зөвлөлтийн цэргийг 1989-1990 онд 75%-иар хорогдуулах болно. Энэ удаагийн цэрэг гаргах ажил М. С. Горбачевыг БНХАУ-д айлчилж эхэлсэн тавдугаар сарын 15-наас эхэллээ. Ийнхүү хоёр улс цэргийн сөргөлдөөний түвшинг багасгах, цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх талаар дорвитой ажиллаж, цаашид хүчин чармайлт гаргахаар тохиролцлоо.

ЗХУ, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны хэмжээ сүүлийн жилүүдэд тогтвортой нэмэгдсээр байна. 1986-1990

онд харилцан бараа, солилцох, төлбөрийн тухай удаан хугацааны хэлэлцээрт зөвлөлт, хятадын харилцааны түүхэнд 1985 онд анх удаа гарын үсэг зуржээ. Хоёр тал үйлдвэр засварлах, хамтарсан үйлдвэр байгуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, хоёр улсын бүгд найрамдах улс, өөртөө засах орон, муж, яам, тусгай газар, үйлдвэр, нэгдлийн хооронд холбоо тогтоон хөгжүүлэх гэрээ хэлэлцээр байгуулсан юм. Цаашдаа энэ хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаа Алс дорнодод ихээхэн хөгжих хандлагатай байна.

ЗХУ, БНХАУ-ын шинжлэх ухаан, техник, соёлын харилцаа холбоо улам бүр өргөжсөөр ирлээ. Эрдэмтэд мэргэжилтэн, оюутан аспирант солилцох, хоёр улсын эрдэм шинжилгээний төвүүд, сургуулиудын хооронд шууд холбоо тогтоох, харилцан мэдээлэл солилцох зэрэг шинжлэх ухаан, боловсролын салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх нь хоёр орны ард түмний харилцан ойлгох, хэлхээ холбоог гүнзгийрүүлэхэд тус дөхөм болно гэж хоёр тал үзэж байна.

Зөвлөлт, хятадын дээд хэмжээний уулзалтыг ЗХУ-д өрнөж буй өөрчлөн байгуулалт, БНХАУ-д хийж буй шинэчлэлтийн зүй ёсны үр дүн гэж хэлж болох юм. Улс орноо хөгжүүлэх, угтаа ард түмнийхээ сайн сайхны төлөө өөр өөрийн онцлог байдалд тохируулан хийж буй өөрчлөн байгуулалт, шинэчлэлтийн адил төсөөтэй тал илүү олон байна.

ЗСБНХУ, БНХАУ-ын гадаад, дотоод бодлогын зорилтууд олон талаар өнгө хослон байгаа нь энэ хоёр улсын харилцааны түүхэн шинэ үеийн гол онцлог гэж хэлж болно. ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга М. С. Горбачев Хятадын олон нийтийн төлөөлөгчидтэй уулзаж хэлсэн үгэндээ «Бие биедээ хүйтэн хөндий байсан урт хугацааны үе бидний ард үлдэж байна. Хамтран төвхнүүлэх учиртай ирээдүй бидний өмнө байна» гэсэн билээ. Үнэхээр хөрш хоёр улсыг сайхан ирээдүй угтан байна.

Хол ойрын хүн ард хотлоороо амар түвшин, аз жаргалтай байхыг эрхэмлэж ирсэн Монголын ард түмэн ЗСБНХУ, БНХАУ-ын харилцаа хэвийн болж байгаад баяртай байна. БНМАУ дэлхий ертөнц дээр хоёрхон улстай хил залган оршиж иржээ. БНМАУ, ЗСБНХУ. БНХАУ-ын ард түмэн эртнээс нааш эдийн засаг, соёлын талаар харилцаж ирсэн түүхэн уламжлалтай билээ. Эрт цагийн түүхэн уламжлалаа ч бодсон, энэ үеийн шинэ сэтгэлгээний үүднээс ч бодсон манай улстай хөрш оршдог ЗСБНХУ, БНХАУ-ын харилцаа хэвийн болж байгаа нь наандаж манай бүс нутаг цаанадаж дэлхийн улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэхэд асар их хувь нэмэр оруулна гэдэгт монголын ард түмэн итгэл төгс байна.